

Батлав. БОАЖЯ-ны Хүрээлэн буй
орчин, байгалийн нөөцийн
удирдлагын газрын дарга

_____ Б.Буяннэмэх

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг
хүлээсэн: “Хавчигийн ам” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал

_____ Б.Баярбаатар

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМ, БУМБАТ-4 НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/ АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-021514 /

/ АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5958989 /

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын шинжээч...../ Ц.Жаргалнэмэх/

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуучлалын

газрын мэргэжилтэн...../ С.Эрдэнэцогт /

Боловсруулсан:

“Хавчигийн ам” ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн...../ Э.Намсрай /

2024 он

Хянасан огноо	
Хянасан мэргэжилтний хувийн дугаар	
Дүгнэлт	
Шийдвэрийн төсөл	
Ололт, амжилттай тал	
Дутагдалтай сул тал	
Шаардлага	

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /...../

огноо

/ он сар өдөр /

НЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД, ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

- Байгууллагын нууцын тухай хуулийн 6.1 болон 6.2-ыг үндэслэн дагуу тухайн төслийн хуулийн этгээд мэдээллийн төрлийн харгалзах мөр, багананд мэдээллийг товч хэлбэрээр үнэн зөв оруулах.
- Тухайн төсөлд хамаарахгүй хэсгийг “*хамааралгүй*” гэж бөглөх.
- 1.2.7 дахь хаалтын дараах зориулалт гэдэгт уурхайн хаалтын дараа нөхөн сэргээсэн газрыг бэлчээр, газар тариалан, агуулах, олон нийтэд зориулсан үйлдвэр, үйлчилгээ гэх мэт тухайн газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулахаар төлөвлөж буй бол орон нутагтай урьдчилан тохиролцсон чиглэлийг оруулах.

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1.1	1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	“Хавчигийн ам” ХХК
	2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9011528127
	3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Ашигт малтмалын ашиглалт,
	4. Аж ахуйн нэгжийн харъяаллын хаяг	Улаанбаатар, Хан-Уул, 15-р хороо, зайсан, Гэгээнтэн, 201 байр 13 давхар, 1303 тоот
	5. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Б.Баярбаатар, 88113110, bayarbaatar.byamba@gmail.com
	6. Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	Б.Баярбаатар, 88113110, bayarbaatar.byamba@gmail.com Э.Намсрай, 90100632, Namsrai927@gmail.com
1.2	1. Төслийн нэр	“Бумбат-4” нэртэй алтны шороон орд
	2. Төслийн харъяаллын байршил	Төв аймаг Заамар сум
	3. Төслийн ангилал	Уул уурхайн төсөл
	а. нүүрс, алт, жонш, төмрийн хүдэр гэх мэт	Алт
	б. ил уурхай, далд уурхай, шороон орд	Ил уурхай
	в. баяжуулах үйлдвэр	Усаар угаан гравитацийн аргаар баяжуулдаг
	4. Төсөл эхэлсэн огноо	2022

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /.....*Намсрай*...../

огноо

12/24 он ...1... сар ...8... өдөр /

5. Төсөл хэрэгжих хугацаа	2 жил
6. Уурхайн хаалт эхлэх огноо	2027
7. Хаалтын дараах зориулалт	Хадлан бэлчээр
8. ТЭЗҮ баталсан огноо	2022
9. Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ /дундаж/	-
10. Ажилчдын тоо	136
11. Тухайн жилийн ажлын ерөнхий төлөвлөгөө	-
12. Тухайн төсөлд хамаарах дэд бүтэц	-
<ul style="list-style-type: none"> • замын урт, эхлэл, төгсгөлийн цэг, чиглэл 	-
<ul style="list-style-type: none"> • шатахуун түгээгүүрийн тоо 	5 тн түлш түгээгүүрийн машинтай
<ul style="list-style-type: none"> • шатахууны агуулахын агууламжийн хэмжээ 	50 тн багтаамжтай 2 агуулах,
<ul style="list-style-type: none"> • тэслэх, дэлбэлэх бодисын үйлдвэрийн хүчин чадал гэх мэт 	Тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэхгүй

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /.....*Мамсрай*...../

огноо

/ 2014 он ...1... сар ...8... өдөр /

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛГОГДДОГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ДҮГНЭЛТ, ЛАВЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай 2.3-ыг үндэслэн хуулийн этгээд тусгай зөвшөөрөлтэй холбогдох доорх мэдээллийг үнэн зөв оруулах.
- Тусгай зөвшөөрөл, ашигт малтмалын нөөц, ТЭЗҮ баталсан хуулийн этгээд, дугаар, огноог оруулах
- Доорх хүснэгтийн 2.1.9, 2.1.10-т тусгагдсан холбогдох 7 материалын хуулбарыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зайлшгүй хавсаргах. Мэдээлэл оруулах багананд хавсралтын нэрийг оруулах.

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
	1. Тусгай зөвшөөрлийн төрөл /ашигт малтмал/ <ul style="list-style-type: none"> • Дугаар • Хүчинтэй хугацаа • Талбай 	Алт MV- 021514 30 жил 1,139.97
2.1	2. Тусгай зөвшөөрлийн төрөл /химийн бодис ашиглах/ Дугаар Хүчинтэй хугацаа	
	3. Химийн бодисын агуулахад хийсэн мэргэжлийн хяналтын газрын тодорхойлолт	
	4. Галын дүгнэлтийн огноо, дугаар	
	5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	2023 “Говь хангайн төгөл” ххк

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /.....*Мамсрэн*...../

огноо

/2024 он ...4... сар ...8... өдөр /

6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд		2023-БОАЖЯ	
7. Ус ашиглалтын дүгнэлтийн огноо		2024	
8. Тухайн жилийн уулын ажлын батлагдсан төлөвлөгөөний огноо		Хавсаргав	
9. Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний 1.1, 1.5, 1.7, 1.9, 1.10, 1.11 дэх маягтыг хавсаргах		Хавсаргав	
10. Нөхөн сэргээлт	Техникийн нөхөн сэргээлтийн талбай /га-аар/	тайлант онд гүйцэтгэсэн төлөвлөгөөт онд гүйцэтгэх	2.4
	Биологийн нөхөн сэргээлтийн талбай /га-аар/	тайлант онд гүйцэтгэсэн төлөвлөгөөт онд гүйцэтгэх	17.3
		тайлант онд гүйцэтгэсэн	2.1
		төлөвлөгөөт онд гүйцэтгэх	6.4
11. ТХГН-ын тухай хууль, гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар тогтоосон хамгаалалтын бүсийн хилийн заагтай давахцсан эсэхийг тодорхойлсон лавлагааг хавсаргах		Хавсаргав	
12.Тухайн жилд баримтлах стандартын дугаар <input checked="" type="checkbox"/> Үндэсний <input type="checkbox"/> Олон улсын		Хавсаргав	

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /.....*Малчрай*...../

огноо

/2024 он1 сар ..8... өдөр /

ГУРАВ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛ, ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3 дугаар хавсралтанд тусгагдсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулгад заасны дагуу химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэсгээс холбогдох мэдээллийг доорх хүснэгтэд оруулах
- Тухайн жилд олон төрлийн химийн бодис ашиглахаар бол байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд химийн бодисын хор, аюул, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар хавсралтаар оруулж, доорх хүснэгтийн 3.1.1-д хавсралтын нэрийг дурдах (хэмжих нэгжийг дурдсан байх шаардлагатай)
- Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд дараах мэдээллийг бүрэн тусгасан тохиолдолд 3.1.2-ын мэдээлэл оруулах хэсэгт “хангалттай” гэсэн дүгнэлтийг оруулна.

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах хэсэг
3.1	1. Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр, хэмжээ /хэмжих нэгж/	Тусгай зөвшөөрөл шаардагдах химийн бодис ашиглахгүй
	2. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө урьдчилан сэргийлэх арга хэмжээ - эрсдэлийн үед авах арга хэмжээ - учруулсан хор уршгийг зайлуулах, бууруулах арга хэмжээ - хохирлын нөхөн төлбөрийг тооцох арга хэмжээ	Хамааралгүй
3.2	1. Шатах тослох материалын нэр төрөл, хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх 2. Тэслэх, дэлбэлэх бодисын нэр төрөл, хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх	Хамааралгүй
3.3.	1. Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ /хэмжих нэгж/ • Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/ • Үйлдвэрийн хог хаягдал /хатуу, шингэн/ Аюултай хог хаягдал	2648 кг
	2. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв	700.0

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /.....*Малмунтай*...../

огноо

/2024 он ...1... сар ...8... өдөр /

**ДӨРӨВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ**

- Доорх хүснэгтийн 4.1.2 - 4.1.7 –д тусгагдсан тухайн жилийн арга хэмжээний төсвийн нийлбэр нь 4.1.1 –д тусгагдана.

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах хэсэг
4.1	1. Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	57 170 000
	2. Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсөв / технологийн зөв шийдэл /	6 750 000
	3. Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	1 700 000
	4. Нөхөн сэргээх арга хэмжээний төсөв /техникийн, биологийн/	25 600 000
	5. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төсөв	20 000 000
	6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	-
	7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	500 000
	8. Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төсөв	-
	9. Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв	2 620 000

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /.....*Мамсрай*...../

огноо

/ 2021 он ...1... сар ...8... өдөр /

ТАВ. МЕТА МЭДЭЭЛЭЛ

- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 39.1.7-д заасныг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчээс доорх хүснэгтэнд тусгагдсан төслийн дэд бүтэц, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний цар хүрээ, орчны хяналт шинжилгээний цэгэн мэдээллийг тусгасан мета мэдээллийг байгаль орчны мэдээллийн санд оруулна.
- Доорх хүснэгтийн мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах баганыг шинжээч бөглөнө.

№	Мэдээллийн төрөл	Мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах хэсэг
5.1	Зурган мэдээлэлд тусгах мэдээлэл	
	Тосгон	
	Хог хаягдлын цэгийн байршил	
	Аюултай хог хаягдлын агуулахын байршил	
	Хаягдлын далан	
	Химийн бодисын агуулахын байршил	
	Орчны хяналт шинжилгээний дээж авах	
	Хяналтын цэгийн байршил	
	Тухайн жилд хуулах хөрс	
	Гадаад, дотоод овоолго	
	Техникийн нөхөн сэргээлтийн талбай	
	Биологийн нөхөн сэргээлтийн талбай	
	Гүний худгийн байршил	
	Дүйцүүлэн хамгаалал хийх газрын байршил	

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /...../

огноо

/ он сар өдөр /

**ЗУРГАА. ТУХАЙН ЖИЛИЙН АРГА ХЭМЖЭЭНЭЭС БАЙГАЛЬ ОРЧИНД
ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС**

- Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөлөөллийн дүн шинжилгээний хэсгээс доорх хүснэгтийн А, Б, В, Г дэх баганд “тодорхойлсон”, “тодорхойлоогүй”, “хамааралгүй” гэсэн 3 төрлийн хариултаас сонгож бөглөх.
- Дүгнэлтийг байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нөлөөллийн дүн шинжилгээний хэсэгт Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэргэжилтэн дүгнэлт гаргана.

Нөлөөллийн ангилал	А. Тооцсон эсэх	Б. Нөлөөллийн цар хүрээг тодорхойлсон эсэх	В. Нөлөөл-лийн эрчмийг тодорхойлсон эсэх	Г. Нөлөөллийн үргэлжлэх хугацааг тодорхойлсон эсэх	Дүгнэлт
<p>6. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл</p> <ul style="list-style-type: none"> • Бохирдуулах • Эвдэх • Доройтуулах 					
<p>6. Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл</p> <ul style="list-style-type: none"> • Бохирдуулах • Нөөцийг бууруулах 					

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /...../

огноо

/ он сар өдөр /

<p>6. Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл</p> <p>амьдрах орчинг хуваах</p> <ul style="list-style-type: none"> • амьдрах орчинг доройтуулах • амьдрах орчинг хомсдуулах • нөөцийг бууруулах 					
<p>6. Агаарт үзүүлэх нөлөөлөл</p> <ul style="list-style-type: none"> • Бохирдуулах • тоос 					
<p>6. Түүх соёлын дурсгалт эд зүйлс</p> <ul style="list-style-type: none"> • Хамгаалах • Нүүлгэн шилжүүлэх 	хамааралгүй	хамааралгүй	хамааралгүй	хамааралгүй	хамааралгүй

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /...../

огноо

/ он сар өдөр /

**ДОЛОО. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ**

- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “А” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх
- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “Б”, “В”, багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг тогтоосон эсэхэд “**Тийм**”, “**Үгүй**” хариулт өгнө.
- Доорх хүснэгтийн “Г” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг оновчтой тогтоосон эсэхэд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэргэжилтнүүд “**хангалттай**” “**хангалтгүй**” гэсэн дүгнэлт өгнө.

Тухайн жилийн байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл	А. Тоо	Б. Шалгуур үзүүлэлтийг тогтоосон эсэх	В. Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг тогтоосон эсэх	Г. Дүгнэлт
1. Нөлөөллөөс урьдчлан сэргийлэх зайлуулах арга хэмжээ	16	Тийм	Тийм	
2. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	16	Тийм	Тийм	
3. Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	17.3	Тийм	Тийм	
• техникийн/ га эзэлхүүн	6.4			
• биологийн /га				
4. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ	Тийм	Тийм	Тийм	
5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ	Тийм	Тийм	Тийм	Тийм
6. Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Хамааралгүй	Хамааралгүй	Хамааралгүй	Хамааралгүй
7. Байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ		Тийм	Тийм	

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /.....*Мамсрай*...../

огноо

/ 2024 он ...1... сар ...6... өдөр /

НАЙМ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийг “А, Б, В, Г” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх

Хяналт шинжилгээний дээж	А. Дээж авах цэгийн тоо	Б. Дээж авах цэгийн байршил	В. Давтамж(удаа)	Г. Төсөв(төг)
1. Хөрс	2	- Нөлөөлөлд өртөөгүй талбай - Шимт хөрсний овоолго -Нөхөн сэргээлт хийгдсэн талбай	2	540,000
2. Ус	2	Уурхайн унд-ахуйн усны зориулалттай гүний худаг Үйлдвэрийн ус цуглуулах эргэлтийн усан сан	2	540,000
3. Амьтан	-		-	-
4. Ургамал	2	Хог хаягдлын бохирын цэгийн орчим	2	540,000
5. Агаар	2	ШТМ-ын агуулах Карьерийн дэргэд Гадаад тээврийн замын дэргэд	2	1,000,000

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /.....*Мамсрай*...../

огноо

/ 2024 он ... 1 ... сар ... 8 ... өдөр /

ГАРЧИГ

1. ОРШИЛ	2
2. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	3
3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	5
4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	8
5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	12
6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	13
7. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	17
8. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	18
9. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	18
10. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	19
11. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	20
12. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ	21
13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	22
14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	24
15. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ ..	25
16. БОМТ-НИЙ ЗАРДЛЫН НЭГДСЭН ХҮСНЭГТ	26

1. ОРШИЛ


Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянах батлах, тайлагнах журмын дагуу боловсруулаа Төв аймгийн Заамар сумын нутаг орших “Бумбат-4” нэртэй алтны шороон орд 2024 онд олборлох явцад гүйцэтгэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ордын ашиглах ТЭЗҮ, БОННҮ, 2024 оны уулын ажлын төлөвлөгөөнд тулгуурлан боловсруулав.

“Бумбат-4” нэртэй алтны шороон орд ашиглах төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд үзүүлэх болзошгүй болон голлох сөрөг нөлөөллийг тогтоож, технологийн шийдлийг зөв сонгон хэрэгжүүлэхтэй холбоотой зайлшгүй дагаж мөрдөх байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр зэргийг уурхай ашиглах техник-эдийн засгийн үндэслэл дээр үндэслэн холбогдох хууль эрхийн бичиг, норм дүрэм, стандарт, заавар журам зэргийн дагуу боловсруулсан.

Уг алтны шороон ордыг ашиглах төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангийн тодотголыг “Говь хангайн төгөл” ХХК 2023 онд хийж батлуулсан.

2. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

ТӨСЛИЙН НЭР:	“Бумбат-4” алтны шороон орд-ыг ил аргаар ашиглах төсөл
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН НЭР: УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ: РЕГИСТРИЙН ДУГААР:	“Хавчигийн ам” ХХКомпани 9011528127 5958989
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ХАЯГ:	Улаанбаатар, Хан-Уул, 15-р хороо, зайсан, Гэгээнтэн, 201 байр 13 давхар, 1303 тоот Харилцах утас: 88113110
АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР:	MV-021514 /1139.97га/
ТӨСЛИЙН БАЙРШИЛ:	Улаанбаатар хотоос баруун хойш 200 км, Төв аймгийн Заамар сумын төвөөс баруун хойш 20 км, “Шижир алт” суурингаас 15 км зайд, байр зүйн зургийн M-48-138 нэрэлбэрт оршино.



Зураг.1 Тусгай зөвшөөрлийн талбайн тойм зураг

“Хавчигийн ам” ХХК
“Бумбат-4” нэртэй алтны шороон орд

“Бумбат-4” нэртэй 1139.97 га бүхий MV-021514 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Улаанбаатар хотоос баруун хойш 200 км, Төв аймгийн Заамар сумын төвөөс баруун хойш 20 км, “Шижир алт” суурингаас 15 км зайд, байр зүйн зургийн M-48-138 нэрэлбэрт орших ба талбайн булангийн цэгүүдийн газар зүйн солбилцолыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Тусгай зөвшөөрөлтэй талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбилцлүүд

№	WGS						UTM	
	Уртраг			Өргөрөг			Өргөрөг	Уртраг
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд		
1	104	35	13.74	48	18	9.52	469383.8318	5350021.148
2	104	35	13.76	48	18	6.28	469383.7056	5349921.11
3	104	35	21.04	48	18	6.31	469533.677	5349921.231
4	104	35	21.19	48	17	46.89	469533.5573	5349321.615
5	104	35	41.72	48	17	27.54	469953.3621	5348721.929
6	104	35	49.47	48	17	30.79	470113.5709	5348821.433
7	104	36	1	48	17	30.79	470351.1322	5348820.191
8	104	36	1	48	15	16.18	470329.4921	5344664.075
9	104	35	15.27	48	15	16.18	469386.5945	5344669.061
10	104	35	15.27	48	15	35.82	469389.8514	5345275.449
11	104	34	33.31	48	15	35.82	468524.7788	5345280.161
12	104	34	33.31	48	15	9.93	468520.3642	5344480.804
13	104	33	59.38	48	14	9.93	467810.2887	5342632.207
14	104	33	59.38	48	14	41.81	467815.8441	5343616.503
15	104	33	54	48	14	41.81	467704.8943	5343617.13
16	104	33	54	48	14	42	467704.9275	5343622.997
17	104	33	53.3	48	14	42	467690.4917	5343623.078
18	104	33	53.3	48	14	41.81	467690.4585	5343617.212
19	104	32	54	48	14	41.81	466467.5368	5343624.273
20	104	32	54	48	14	48.81	466468.8078	5343840.398
21	104	33	31	48	14	48.81	467231.816	5343835.962
22	104	33	31	48	16	33.82	467250.4539	5347078.162
23	104	33	55	48	16	33.82	467745.0967	5347075.34
24	104	33	55	48	16	45.82	467747.1949	5347445.842
25	104	35	7.01	48	16	45.82	469231.2331	5347437.631
26	104	35	7.01	48	17	1.82	469233.9021	5347931.636
27	104	34	43	48	17	1.82	468739.1282	5347934.331
28	104	34	43	48	17	43.83	468746.2497	5349231.403
29	104	35	5	48	17	43.83	469199.5003	5349228.932
30	104	35	5	48	18	9.51	469203.7911	5350021.811
31	104	35	8.89	48	18	9.51	469283.9229	5350021.378

Уулын ажлын төлөвлөгөө

2024 онд “Бумбат”-4 нэртэй алтны шороон ордын MV-021514 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн Баруун шандын хэсгийн 4-В, 5-В, 6-В, 7-В, 8-В, 9-В, 10В-р нөөцийн блок, Цагаан чулуутын дээд хэсгийн III-В, IV-В, V-В, 3-В, 4-В, 5-В, 6-В-р блокуудыг олборлохоор төлөвлөөд байна.

“Бумбат”-4 нэртэй алтны шороон ордын алтын шороон ордын MV-021514 талбайн хэмжээнд 2024 онд дараах уулын ажлыг хийж гүйцэтгэнэ.

Үүнд :

- хөрс хуулалт – 7,120.6 мян. м3
- элс олборлолт, угаалт – 201.63 мян.м3
- алт олборлолт – 170.16 кг /химийн цэврээр/

2024 оны 3-р сарын 15-с Баруун шанлын хэсгийн 4-В-р блок, Цагаан чулуутын дээд хэсгийн 3-В-р блокоос хөрс хуулалтын ажил эхэлнэ. Эдгээр блокуудын хөрс хуулалт, элс олборлолтыг экскаватор автосамосвалын хосолсон схемээр хийж гүйцэтгэнэ.

Экскаватороор хөрс хуулалтыг автосамосвалд ачин урд жилийн олборлолт хийгдсэн талбайд болон ашиглагдсан хоосон орон зайд дотоод овоолгоор нөхөн сэргээлт хийхээр төлөвлөж байна

3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Байгаль газарзүй: Тус сум нь УБ хотоос 180 км, өөрийн аймгаас 225 км алслагдан оршдог бөгөөд Төв аймгийн Угтаал, Цээл, Лүн сум Булган аймгийн Баян нуур, Бүрэгхангай, Сэлэнгэ аймгийн Орхон туул сумтай хиллэж нийт 280.3 мянган га нутаг дэвсгэртэй. Газар тариаланг эрчимтэй чиглэлээр хөгжүүлэхэд тохиромжтой бөгөөд бүх нутгийн 60 шахам хувийг малын бэлчээрт ашиглах боломжтой байсан бол одоо 30 орчим хувийг мал аж ахуйн бэлчээрт ашиглаж байна. Нүүрс, төмрийн хүдэр, алт, зэс төрөл бүрийн болор гялтагнуур, хужир шүү элбэгтэй. Цайдам, Баржин, Хайлаастай зэрэг үе мөч, дотрын өвчнийг анагаахуйц рашаан устай.

Уур амьсгал: Төв аймгийн нутаг нь тайга, ойт хээр, хээрийн бүсэнд оршдог бөгөөд өндөршилийн ялгаа багатай байдаг учраас дулаан хүйтний хэлбэлзэл багатай юм. Тус аймгийн Туул, Хэрлэн, голын сав дагуух буюу далайн түвшнээс дээш 1250 метрээс дээш өргөгдсөн нутагт жилийн дундаж агаарын температур -11-20 градус хүйтэн байгаа нь өвлийн улиралд бусад нутгаас арай илүү хүйтэн байдагтай холбоотой юм. Жилийн хамгийн хүйтэн сар нь 1 дүгээр сар бөгөөд, олон жилийн дунджаар температур –20.2...26.6°C, хамгийн дулаан сар нь 7 дугаар сар бөгөөд агаарын дундаж температур 15.7°C...18.9°C байдаг. Сүүлийн 30 жилд агаарын температур дунджаар 1.2°C -аар дулаарч байна.

Хөрсний гадаргын температурын тухайд 1 дүгээр сард дундаж температур 20°С....25°С, 7 дугаар сард дундаж температур 21.0°С...26°С байдаг. 1983-2012 оны агаарын температурын сарын дундаж утгыг 2014-2018 оны агаарын температурын дундаж утгатай харьцуулахад агаарын температур 2-5 градусаар нэмэгдсэн байна.

Хур тунадас: Монгол орны нутаг дэвсгэрт жилийн хур тунадасны ихэнх нь зуны улиралд унах бөгөөд энэ зүй тогтол Заамар сумын тунадасны хувьд ч адил. Зуны саруудад дунджаар 35-60 мм тунадас унадаг бол, өвлийн саруудад харьцангуй бага тунадас унадаг. Мөн ойролцоо сумдын аадар болон зүс бороотой өдрийн тооны харьцааг үзэхэд сүүлийн жилүүдэд зүс бороотой өдрийн тоо нь багасаж, богино хугацаанд усархаг аадар тунадас ажиглагдах нь ихсэх төлөвтэй байгаа юм

Гадаргын ус: Орд орших Цагаан чулуутын хөндий нь Туул голын баруун гар талын хуурай цутгал хөндийнүүдийн нэг болох Хайлаастын хөндийн зүүн дээд салаа юм. Хайгуул гүйцэтгэсэн орд нь Цагаан чулуутын хөндийн дээд эхэнд, Заамарын усан хагалбарын ар хормойн хэсэгт байршина. Судалгааны талбайн баруун талаар урсах Туул гол түүний томоохон цутгалан Хар бухын гол, Нарийн гол, жижиг салаанууд болох Ар наймган, Хайлааст, Бичигт хошууны гол болон Цайдам, Хүйтэн, Их цагаан зэрэг нуурууд, жижиг булгууд гадаргуугийн усан сүлжээг бүрэлдүүлдэг. Туул голын хөндийн өргөн нь 100 м-ээс километр илүү, хөндийн хөндлөн огтлолын хэлбэр нь тэвш маягтай, хоёр тал нь ижил бус бөгөөд хажуунаасаа уулсаар шахагдсан байдаг. Гольдролын өргөн нь 40-60 м, гүн нь харгиан дээрээ 0.4-0.5 м, бусад газраа 2 м түүнээс илүү гүнтэй, ихээхэн тахиралдсан салаа, булан тохой, хар ус ихтэй. Эрэг нь намхан 0.6-1.5 м, тасархай, зарим газраа тэгширсэн, голдуу элсэнцэр-шавраас тогтоно

Ус зүй: Монгол орны ай савын ангиллаар Хойд Мөсөн Далайн ай савд багтдаг. Төв аймгийн нутаг дэвсгэрээр урсан өнгөрөх голууд нь гол мөрний горимын ангиллаар хаврын шар усны ба дулааны улирлын хур борооны үертэй голуудад хамаардаг. Хайгуулын талбай нь Туул голын ай савд байрлана. Туул гол Хан Хэнтий нурууны салбар уулс болох далайн түвшнээс дээш 2000 м өндөрт өргөгдсөн Чисаалайн сарьдаг, Шороотын давааны өврөөс гарах , Шороотын давааны өврөөс гарах Намъяа, Нэргүй хэмээх хоёр голын уулзвараас эх авна. Хэнтийн нурууны салбар уулсаас эх авсан Галттай, Сарьдагийн Хийд, Хаг, Хонгор, Зүүн Баян, Тэрэлж, Хөлийн гол, Улиастай, Сэлбэ, Харбух зэрэг гол, горхи Туул голд цутгадаг. Туул голын хөндий Улаанбаатар хотоос доош тавиурч урцын алдагдал ихэснэ. Туул гол үерлэхдээ сав хөндийгөө дүүргэж, хуучин гулдиралдаа эргэн орж, үндсэн гулдирлаас алслан салаалдаг. Туул голын өргөн нь жирийн үед 35-37 м, гүн нь 0.8-3.5 м, урсгалын хурд 0.50-1.50 м/с болно. Голын ус хурах талбай 49840 ам км, урт нь 704 км.



Зураг 2. Туул гол сав газар

Хөрсөн бүрхэвч: Тус хайгуулын талбай нь Заамар сумын баруун талд Авдарантын овооны (1796.4м) баруун хойт талд нам уулс бүхий түүний хоорондох нугачаат хөндийд байрлана. Энэ газар нь Хөрс-газарзүйн мужлалтаар Туул-Дашинчилэнгийн 2-р тойрогт багтана. Тус уурхайн талбайн хөрсөн бүрхэвч уулархаг гадарга, түүний бэл, хөндий, нуга, сайр зэрэг гадаргуугийн олон шинжээс бүрдэж, хөрсөн бүрхэвч нь харилцан адилгүй шинж чанартай байна. Талбайд уулын болон хөндий хотгорын хар шороон болон хар хүрэн, нугын бараан зэрэг олон хэв шинжийн хөрс тархана.

Ургамлан нөмрөг: Энэ нутаг нь ургамал-газарзүйн тойргийн хувьд Монгол Дагуурын ойт хээрийн тойрогт багтдаг, хээрийн ургамал зонхилдог. Н.Өлзийхутагийн (1985) тэжээлийн ургамал таних бичигт 73 овгийн 379 төрлийн 1234 зүйл ургамал орсон байдгаас Заамар суманд 65 овог 108 төрөл 199 зүйл ургамал байна. Энд Үетэн, Голгэсэртэн, Буурцагтан, Луулийн овгууд нь зүйлийн тоогоор тэргүүлнэ. Төв аймгийн Заамар сумын бүс нутаг Монгол орны ургамлын 16 тойргийн ангиллаар бүхэлдээ Монгол Дагуурын уулын ойт хээрийн тойрогт багтдаг. Ургамлын байгалийн бүс бүслүүрийн ангиллын хувьд Заамар сумын нутаг нь цөлийн хээр, өндөр уулын, уулын ойт хээр, уулын хээр, бэлчээрийн бус, хээр ба хуурай хээр гэсэн ангилалд хамаарна. Судалгааны талбайн орчимд бэлчээрийн бус, хээр ба хуурай хээр, уулын хээрт зонхилох ургамлууд голлон ургасан байна. Ургамлын хэв шинж нь уул хоорондын хөндий, бэлийн хялганат хээрийн төрхтэй юм.

Амьтан: Төв аймгийн Заамар сум нь амьтны газарзүйн мужлалын хувьд Монгол дагуурын тойрогт тойрогт багтана. (А.Г.Банников, 1954). Төслийн талбайн эргэн тойронд өмнө оршиж байсан зэрлэг амьтад дайжиж дүрвэсэн бөгөөд хүний үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн газар тархах чадвартай зүйлүүд болох гэрийн хулгана, хар хэрээ, оронгийн бор шувуу, хадны тагтаа, хүрээний хараацай, жижиг шавжийн ангийн амьтад түгээмэл тохиолдоно.

Хөхтөн: Заамар сум орчимд 36 зүйлийн махчин, туруутан, мэрэгч тэн зэрэг хөхтөн амьтан тархсан байна. Эндээс бүс нутгийн хэмжээнд 24 зүйл анхааралд өртхөөргүй, 5 зүйл мэдээлэл дутмаг, 2 зүйл устаж болзошгүй, 5 зүйл ховордож болзошгүй гэсэн ангилалд багтаж байна. Харин олон улсын үнэлгээгээр 33 зүйл анхааралд өртхөөргүй, 2 зүйл ховордож болзошгүй, 1 зүйл эмзэг гэсэн статустай байгаа юм.

Шувуу: Заамар сумын орчимд, Туул голын сав газарт 102 зүйл шувуу тэмдэглэгдсэн байна. Энэ бүс нутагт тохиолдох шувуудын бүс нутгийн статусыг авч үзвэл ховордож болзошгүй 3 зүйл, эмзэг 5 зүйл, устаж болзошгүй 2, устаж байгаа 1 зүйл, харин олон улсын үнэлгээгээр ховордож болзошгүй 5 зүйл, эмзэг 3 зүйл, устаж болзошгүй 2, устаж байгаа 1 зүйл тус тус байна.

Хоёр нутагтан, мөлхөгч: Тус сумын орчимд 5 зүйл хоёр нутагтан, мөлхөгч тархсан бөгөөд эдгээр нь түгээмэл тохиолддог зүйлүүд учир бүс нутгийн болон олон улсын хамгааллын статуст анхааралд өртхөөргүй, үнэлгээ хийгдээгүй гэсэн ангилалд багтдаг.

Монгол орны гол, мөрөн, нууруудад нийт 74 зүйл загас тархсан. Монгол улсын загасны улаан дансанд тэмдэглэснээр Туул голын сав газарт 8 зүйл загас бий.

Нийгэм эдийн засгийн байдал: Заамар сумын нийт газар нутгийн хэмжээ 281207 га. Үүний 252863 га талбайг хөдөө аж ахуйн газар 89.9%, 5546 га талбайг ойн сан бүхий газар 2%, 1762 га талбайг усан сан бүхий газар 0.6%, 19080 га талбайг тосгон, суурингийн газар 6.8%-ийг тус тус эзэлнэ. Сумын төсвийн нийт орлого нь 2017 оны байдлаар 78.3 сая төгрөг бөгөөд улсын төвлөрсөн төсвийн санхүүжилт авдаггүй, сумын өөрийн орлого 77.8 сая төгрөг төсөвт байгууллагын өөрийн орлого 0.5 сая төгрөг байна. Орон нутгийн нийт төсвийн зардал нь 2058.0 сая төгрөг байна. Нийт зардлын 61.4 хувь нь цалин, 6,8 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл, 31.8 хувийг урсгал шилжүүлэг болон бусад зардал эзэлж байна.

Хүн ам дэд бүтэц: Төслийн талбай нь Заамарын алтны зангилаа бүсийн төвд байрладаг учраас цахилгаан хангамж, авто замын сүлжээ, усан хангамж, түлш, модон материалаар уурхайг хангахад эдийн засгийн хувьд үр ашигтай болох нь тодорхой юм. Тус суманд 12 жилийн сургууль, 10 жилийн сургууль болон хоёр цэцэрлэг, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, бүс дундын цагдаагийн газар, хоёр хүн эмнэлэг болон бусад үйлдвэр үйлчилгээний газрууд үйл ажиллагаагаа явуулж байна.

4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Хавчигийн ам” ХХК-ийн “Бумбат-4 нэртэй алтны шороон орд олборлох үйл ажиллагааг хэрэгжүүлэх үед сөрөг нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг БОННУ-гээр тодорхойлов. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, түүнд өртөх байгаль орчин, тухайлбал, газрын гадарга хэвлий, агаар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг, иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг чиглэл бүрээр гаргаж тусгасан. Мөн тэдгээр гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн эрчим, тархалт, хэмжээг тодорхойлж, тоон ба чанарын үнэлгээ өгсөн дүнгүүдийг тусгасан болно.

Магадлан жагсаах арга буюу хяналтын хуудасны арга нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн төрлийг жагсаан тэдгээрийг төсөлтэй холбоотойгоор харьцуулан тодорхойлсон хүснэгт бүрдүүлэх арга юм. Энэ аргын үр дүн төслөөс хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулах нөлөөллийг тогтооно.

Харин матрицын арга бол тухайн төслийн үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэх явцад байгаль орчин учруулах эерэг, сөрөг нөлөөллийг уялдуулан авч үзэж, нөлөөллийг бүрэн тодорхойлох боломж өргөнтэй арга юм. Үр дүн нь мөр болон баганын нийлбэр тоон үзүүлэлт нь цаашид төслийн аль үйл ажиллагаа эсвэл орчны аль хэлбэрт илүү анхаарал тавихыг тогтооход ашиглагдана.

“Хавчигийн ам” ХХК
“Бумбат-4” нэртэй алтны шороон орд

Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах байдал

Байгаль орчны үзүүлэлтүүд	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
Байгалийн экосистемийн өөрчлөлт										
Газрын доорх урсацын өөрчлөлт		х		х		х				х
Гадаргын усны урсацын өөрчлөлт	х			х			х		х	
Ургамлын бүтцийн өөрчлөлт	х			х		х			х	
Хөрсний элэгдэл, эвдрэл	х			х			х	х		
Геологийн тогтцын өөрчлөлт	х			х			х	х		
Зэрлэг амьтдын орон зай	х			х					х	
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		х	х	х		х				х
Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын доорх нөөц баялаг	х			х			х	х		
Бэлчээрийн байдал	х			х		х			х	
Байгаль орчны чанарын өөрчлөлт										
Газар доорх усны чанарын өөрчлөлт	х				х	х				х
Гадаргын усны чанарын өөрчлөлт	х			х						х
Агаарын бохирдол	х			х		х			х	
Хөрсний бохирдол	х				х	х			х	
Хорт бодис усаар дамжин хүн ам, ан амьтанд нөлөөлөх										
Дуу чимээ, шуугианы нөлөө	х			х		х			х	
Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	х				х		х	х		
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	х				х		х	х		
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх										
Эдийн засаг, нийгмийн асуудал										
Орон нутгийн орлого нэмэгдэх	х			х		х			х	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		х		х		х			х	
Ажлын байр нэмэгдэх	х			х		х			х	
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	х			х		х				х
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		х		х			х			х
Бусад нөлөөлөл										
Үйлдвэрийн барилга байгууламжийг барих үед орчны хөрсний эвдрэл, бохирдол гарах	х			х		х		х		

“Хавчигийн ам” ХХК
“Бумбат-4” нэртэй алтны шороон орд

Ахуйн болон үйлдвэрийн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс ба газрын доорх усыг бохирдуулах	x			x		x			x	
Химийн бодис, үйлдвэрийн хаягдал, барилгын материалын хаягдал зэргээс байгаль орчинд сөргөөр нөлөөлөх	x			x		x				x
Хүчтэй салхи, түймэр газар хөдлөл, аянга цахилгаан		x		x		x				x
Дүн	20	5	1	21	4	16	7	6	11	8

Төслийн үйл ажиллагаанаас үүдэн гарч болох байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөлөл нь үйлдвэрийн технологийн онцлогоос хамаарч байгалийн экосистем, байгалийн нөөц, байгаль орчны чанарт сөрөг, харин улсын болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн асуудалд эерэг нөлөөтэй байгаа нь дээрх хүснэгтээс харагдаж байна. Иймд тэдгээрт задлан шинжилгээ хийж дараах дүгнэлт өгч болох юм. Үүнд:

Шууд ба шууд бус нөлөөлөл, түүний эрчим: Болзошгүй нөлөөллийн 20 нь шууд нөлөөлөлд хамаарах бөгөөд үүний 4 нь буюу нийгэм-эдийн засагт эерэг нөлөөтэй байна. Өөрөөр хэлбэл дээрх болзошгүй нөлөөллүүдийн ихэнх нь шууд нөлөөлөлд хамаарч буй бөгөөд хөрс хуулах, элс олборлох, элсийг зэргэлдээх уурхайн усан санруу тээвэрлэх зэргээс экологийн тухайн системд шууд нөлөөлөхөөс гадна байгалийн баялаг болох гадаргын усыг ашиглан угаан баяжуулалтыг гүйцэтгэж буй нь гадаргын усны урсац, горим ба нөөцөд дундаас хүчтэй зэргийн нөлөөтэй байна. Харин төслийн үйл ажиллагаа эхлэх үед орон нутгийн орлого нэмэгдэх, ажлын байр шинээр бий болох, ядуурлыг бууруулахад тодорхой хэмжээгээр дэмжлэг болоход шууд эерэг нөлөөлөл нь дунд зэрэг нөлөөтэй байгаа нь хүснэгтээс харагдаж байна. Уурхайн тосгон болон бусад барилга байгууламжуудыг барих үед хөрсний элэгдэл, эвдрэл гарах, түүнтэй уялдан орчинд тоос, хүнд машин механизмын яндангаас гарах утаа, хий зэрэг нь агаарын орчныг дунд зэрэг бохирдуулах нөхцөлтэй байна. Харин санамсар, болгоомжгүйгээс нефтийн бүтээгдэхүүн, алдсан тохиолдолд орчны хөрс бохирдуулах магадлал ихтэй тул шууд, дунд зэргийн эрчимтэй нөлөөлөлд хамааруулж үзсэн болно. Богино хугацааны ийм хэлбэрийн нөлөөлөл нь эргээд хүн ам, ан амьтанд нөлөөлөх, үйлдвэрийн барилга байгууламжийг барих үед орчны хөрсний бохирдол гарах, ахуйн болон үйлдвэрийн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс ба газрын доорх усыг бохирдуулах, хүчтэй салхи, түймэр, газар хөдлөл, аянга зэрэг байгалийн гамшгийн үзэгдлүүдтэй холбоотой сөрөг нөлөөлөл орж байна.

Нөлөөллийн хугацаа: Энэхүү төсөл нь батлагдсан ТЭЗҮ-ий дагуу нийт 2 жилийн хугацаанд хэрэгжих тул нийт нөлөөллийн дийлэнх нь богино хугацааны нөлөөлөлд хамруулж үзсэн болно. Ингэхдээ нийт нөлөөллүүдийн 21 нь богино, 4 нь урт хугацааны нөлөөлөлд хамаарагдаж байна. Уурхайн олборлолтын улмаас газрын доорх баялагийг авч ашиглах болон хэдий нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн ч ландшафтын хэлбэр, өнгө нь унаган байдалдаа орохгүй тул урт хугацааны нөлөөлөлд хамруулан үзсэн. Мөн уурхайн үйл ажиллагааны улмаас санамсар болгоомжгүйгээр их бага хэмжээгээр алдаж, асгасан тохиолдолд хөрсөн бүрхэвч улмаар газрын доорх усны чанарт сэргөөр нөлөөлөх бөгөөд байгалийн аясаар цэвэрших боломж бага тул урт хугацааны нөлөөлөлд мөн хамруулан үзсэн болно.

Буцаж нөлөөлөх: Үүнд ахуйн болон нефтийн бүтээгдэхүүнээр бохирдсон хөрс, гүний усыг бохирдуулах улмаар хүн, мал, амьтны эрүүл мэндэд шууд ба шууд бусаар эргэж нөлөөлөх, ахуйн хаягдлыг тухай бүр устгаагүй болон ариутгаагүйгээс болж хаягдлын цэгт ялаа шавж үржих, улмаар хүн, малд буцаж нөлөөлөх талтай. Гал алдсаны улмаас хээрийн түймэр гарч ойр орчмын бусад объект болон ургамалд нөлөөлөх магадлалтай.

Буцалтгүй нөлөөлөл: Энэ төрөлд тухайн сөрөг нөлөөлөл нь байгаль орчинд буцаж нөхөн сэргээх нөхцөл багатай болон сэргээгдэшгүйгээр нөлөөлөх нөлөөлөлд хамаарагдах бөгөөд үүнд газрын доорх усны Урсацын өөрчлөлт, хөрс, газрын элэгдэл эвдрэл, байгалийн үзэсгэлэнт төрх, ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх зэргийн сөрөг нөлөөллөөс гадна бүх эерэг нөлөөллүүд хамаарч байна. Дээрх байдлаас үзэхэд уг алтны шороон ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн үргэлжлэх хугацаа богино хэдий ч эрчмийн хувьд 10 нөлөөлөл хүчтэй, 9 нь дунд зэрэг байгаа нь нөхөн сэргээх, үүссэн сөрөг нөлөөг багасгах арилгах асуудлыг үйлдвэрийн үйл ажиллагааны үед мөрдөх байгаль хамгаалах болон нөхөн сэргээх төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан ажилтай нарийн уялдуулан хийж байх нь зайлшгүй болохыг дахин баталж байна.

5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн бичиг баримт юм.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон сөрөг нөлөөллийг тодорхой хугацааны давтамжтай хянах, тайлагнах, бууруулах, арилгах арга хэмжээ авахад, нь тус байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилго оршино.

Үүнд:

- Байнгын хяналт шинжилгээ хийснээр төслөөс орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг тухай бүрт эрт илрүүлэх
- Тухайн илрүүлсэн сөрөг нөлөөллийг үндэслэн тодорхой цаг хугацааны дотор байгаль хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах
- Хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хийлгэн төр захиргааны байгууллагууд болон төсөл хэрэгжих орон нутгийн оршин суугч, иргэдэд танилцуулж байх нь төслийн цаашид тогтмол хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх юм.

6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ сая.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая. төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Агаарын чанар								
1	Тоосжилт болон бохирдуулагчийн нөлөөгөөр орчны агаар бохирдох, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Уурхайн ашиглагдах автомашинуудын хурдыг тухайн үеийн нөхцөл байдалд тохируулан ажиллах. Өдөр бүр ажил эхлэхээс өмнө жолооч, оператор нарт машин, техникийн хурдыг тохируулж ажиллах заавар зөвлөмжийг өгч байх	Элс болон хөрс тээврийн зам	-	-		ҮАЗ	Төсөл хэрэгжих хугацаанд өдөр бүр	ЗТБХБ-ын сайдын 2011 оны 216 тоот тушаал. MNS4585:2007
2		Агаарын бохирдлын мониторингийн цэгүүд байгуулж орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу жил бүр хяналт явуулах. Жил бүр олборлолтын ажил эхлэх үе буюу 4-5 саруудад эхний хэмжилтийг хийж байх. Мөн давтан шинжилгээг 9 сард хийлгэж байх	Төслийн хүрээнд		-	Элс болон хөрс тээвэр лэх зам		2024 он 2 удаа	
3		Агаарын бохирдлыг хянах байнгын харуулын цэг байгуулах бол үл тоосрох гадаргуутай хатуу хөрс, цардмал талбай, зүлгэн дээр зүг бүрээс нь салхилах боломжтой задгай газар, өөрөөр хэлбэл ажиглалт, хэмжилтэд нөлөөлөх барилга, ногоон зурвас зэрэг зүйлс ойр орчимд нь байхгүй газар байрлуулбал зохино.	Төслийн хүрээнд	-	-	-	-	-	Агаарын тухай хууль 9, 11, 23-р зүйл MNS 4585:2007 MNS 5919:2008
4		Шатахуун хадгалах сав, дотоод шаталтын хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл, машин механизмуудаас ажлын үед гарах шатах тослох материалын агаар дахь ууршилтын хэмжээг зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага байлгахад технологийн хувьд зөв сонголт бүхий техник хэрэгсэл ажиллуулах, засвар үйлчилгээг	Төсөлд ашиглагдах бүх автомашин	Ширхэг	-	37-н тээврийн хэрэгсэл	-	2024 он	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ

“Хавчигийн ам” ХХК

“Бумбат-4” нэртэй алтны шороон орд

		чанартай хийх. Автомашинуудыг жил бүрийн улсын үзлэг оношилгоонд оруулж байх зөрчилтэй автомашинуудыг ашиглахгүй байх							MNS5885:2008
2	Гадаргын ба газрын доорх усны нөөц								
1	Газрын доорх усанд хомстол үүсэх	Алт угаах зорилгоор байгуулсан нуур цөөрмийн усны бохирдол нь газрын доорх усанд шууд нөлөөлөх тул газрын доорх усанд бохирдуулах бодис (хорт бодис, хог хаягдал, тос, шатахуун, бохир ус г.м) оруулахаас тогтмол урьдчилан сэргийлэх	Төслийн хүрээнд	-	-	-	ҮАЗ	2024 он	Усны тухай хууль 31.2 зүйл Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль Усны тухай хуулийн 24.2-р заалт (MNS 4943:2011)
2		Хаягдал усыг монгол улсын хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус стандарт шаардлагад нийцүүлэн цэвэрлэж, хөрсөнд хаях	Төслийн хүрээнд		-	-	ҮАЗ		
3	Усан орчин бохирдох	Хүнд механизмын түлш, шатахуун зэрэг усыг бохирдуулагч бодис хаяж асгахгүй байх шаардлагатай. ШТМ-иар бохирлогдсон болон ахуйн бохирдол бий болсон хөрс хур борооны үеэр угаагдан гадаргын болон гүний усыг бохирдуулж болзошгүйг анхаарч ажиллах	Төслийн хүрээнд				ҮАЗ	2024 он	Усны тухай хуулийн 24.2-р заалт (MNS 4943:2011)
4		Тосгон ба ордыг хаврын шар усны болон хур борооны үерээс хамгаалах арга хэмжээ авч хамгаалалтын далан шуудууг засаж сайжруулж байх	Төслийн хүрээнд				ҮАЗ	2024 он	
3	Хөрсөн бүрхэвч								
1	Хөрс сийрэгжих, үржил шим алдагдаж доройтох	Ашиглалтын үед хуулсан үржил шимт хөрсний овоолгыг нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний дагуу ашиглах, шимт хөрсний овоолгыг удаан хадгалахгүй байх.	Шимт хөрсний овоолго	мян. м ³	-			2024 он шимт хөрсний овоолго	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль MNS 5916:2008
2	Шатах тослох материал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас	Шатах тослох материал асгарч алдагдах, тархах зэргээс учруулах нөлөөллийг хязгаарлах зорилгоор засварын талбай болон шатах тослох материал хадгалах хэсгийн талбайг хөрсөнд нэвчихээс хамгааллаж хайрга дайргаар хучилттай болгох, бохирдол хур тунадас,	Засварын талбайд	-	-		Үйл ажиллагааны зардал	2024 он	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс.

“Хавчигийн ам” ХХК

“Бумбат-4” нэртэй алтны шороон орд

	үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	үерийн усны урсацаар угаадаж орчинд тархахаас сэргийлж шаардлагатай хэсгүүдэд суваг шуудуу татах							Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга
3		Шатах тослох материал нь органик нэгдлүүдийн нийлмэл бөгөөд хөрсөнд нэвчсэн тохиолдолд түүний гүнд ихээхэн хэмжээний бохирдлыг бий болгон удаан хугацаагаар хадгалагддаг онцлогтой. Ингэж бохирдсон хөрсийг хуулан авч тусгаарлагч гадаргуу дээр овоолон 18-20%-ийн хлораминий уусмалаар бороожуулан ариутгаж эсхүл бууц хольж асган саармагжуулалт хийх	Засвар талбайд	-	-		1.0	2024 он	
4	Ургамлан нөмрөгт								
1	Уурхайн болон ажилчдын хотхоны үйл ажиллагааны улмаас ургамлан бүрхэвч доройтох	Нөхөн сэргээлтээр ургуулсан ургамал бүхий газарт эхний 2 жилд мал бэлчээрлүүлэхээс сэргийлж, хашиж хамгаалах	АМТЗ-ийн талбайд	ш	-		ҮАЗ	2024 он	Ургамлын тухай MNS 5916-2008
2		Ургамалжуулах ажлыг эхний ээлжид зохиомол аргаар хийх бөгөөд цаашид байгалийн аясаар хөрс болон ургамалан бүрхэц тогтвортойгоор бүрдэх нөхцөлийн хангах	АМТЗ-ийн талбайд				ҮАЗ	2024 он	
3		Техникийн нөхөн сэргээлт хийж байгаа хэсэгт хуулж нөөцөлсөн үржил шимт ялзмагт хөрсөөр аль болох их зузаантай /10 см- ээс багагүй/ хучиж хөрсжүүлэх	АМТЗ-ийн талбайд				ҮАЗ	2024 он	

“Хавчигийн ам” ХХК

“Бумбат-4” нэртэй алтны шороон орд

4		Ургамлан нөмрөгийг устах, талхлагдахаас сэргийлж хүн, техникийн хөдөлгөөнд хязгаарлалттай тавьж авто замуудаар зорчих хөдөлгөөнийг хэвшүүлж хяналт тавьж ашиглах, шороон асгацууд бий болгохгүй байх, талбайн ашиглалтын зохион байгуулалтыг сайжруулах	АМТЗ-ийн талбайд				ҮАЗ	2024 он		
5	Амьтаны аймаг									
1	Уурхайлалтын үед ан амьтанд үзүүлэх нөлөөлөл багасгах	Зэрлэг амьтдыг хамгаалах биотехникийн арга хэмжээг орон нутгийн захиргаатай хамтран зохион байгуулж ажиллах нь зүйтэй. Ингэхдээ өвөл, хаврын тарчиг цагуудад хужир, мараа болон өвс тэжээл байршуулах замаар хэрэгжүүлэх нь зүйтэй	АМТЗ-ийн талбайд			Орон нутгаас санал авах	ҮАЗ	2024 он	Амьтны тухай хууль	
2		Уурхайн цахилгаан, холбооны шонгууд дээр шувуу үүр засахаас сэргийлж хамгаалалт, үргээгч байрлуулах	АМТЗ-ийн талбайд		20		ҮАЗ	2024 он		
3		Уурхайн элс тээврийн зам дагуу осол гарч болзошгүй буюу мал, амьтан өнгөрөн гардаг (ус уухаар явдаг жимийн огтлолцол) хэсгүүдэд тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах	АМТЗ-ийн талбайд				ҮАЗ	2024 он		
4		Уурхайн ажилчдыг хууль бус агнуур хийх, амьтны үр зулзага, үүр өндгийг сүйтгэх зэрэг зөрчлийг гаргуулахгүй байхад анхаарч ажиллах	АМТЗ-ийн талбайд				ҮАЗ	2024 он		
							6.75			

7. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөхөн сэргээлтийн зорилго	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж Га	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоохэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1		2	3	4	5	6	7	8
Техникийн нөхөн сэргээлт								
1.	Эвдрэлд өртсөн талбайд техникийн нөхөн сэргээлт хийх	Баруун шанд хэсэгт	га	-	17.3		2024	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, /MNS 5917-2008/
Биологийн нөхөн сэргээлт								
2.	Уурхайн ашиглалтын талбайд эвдрэлд өртсөн талбайг нөхөн сэргээх	Жил бүрийн техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайг Ургамалжуулах / Баруун шанд хэсэгт /	га	-	6.4	25 600	2024	”Эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага” /MNS 5918-2023/
	Нийт					25.600		

2024 онд ашиглалтын үйл ажиллагаагаар 22.52 га талбайг эвдрэлд оруулах ба техникийн нөхөн сэргээлтээр нийт 17.3 га, биологийн нөхөн сэргээлтээр 6.4 га талбайг нөхөн сэргээхээр төлөвлөж байна. Үйл ажиллагаа явуулахад эвдрэлд орох 22.52 га талбайн 45.040 мян.м3 үржил шимт хөрсийг хуулж, хадгална. Шимт хөрсний овоолго болон техникийн нөхөн сэргээлт хийхдээ холбогдох хууль, журам, стандартыг баримтлан хийх болно.

8. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8
1	Дүйцүүлэн хамгааллын ажил хийх талбайг орон нутгийн удирдлагатай тохиролцон сонгох	Орон нутгийн удирдлагаас санал авах			-		2024 он	Байгаль орчны үнэлгээний тухай хууль
2	Дүйцүүлэн хамгааллын хэрэгжүүлэх ажлыг хийх			5	-	20	2024 он	
	Нийт					20		

9. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд орших иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллагыг зайлшгүй нүүлгэх шаардлагатай болсон “Ашигт малтмалын тухай” хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна.

№	Нөлөөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Уурхайн ойр, орчим болон нөлөөллийн бүсэд нутаглаж амьдардаг иргэд	Шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох	АМТЗ-ийн талбай болон нөлөөллийн бүсийн айл	-	-	Харилцан тохиролцооны үндсэн дээр	2024 он	“Ашигт малтмалын тухай” хуулийн 41 дүгээр зүйл
	Нийт					-		

10. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уг төслийн БОНБНУ-ний хээрийн хэмжилт судалгааны үеэр АМТЗ-ийн талбайд нүдэнд ил харагдах түүх соёлын дурсгалт зүйлс ажиглагдаагүй байна. Гэвч бид “Түүх соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийг сахин биелүүлэх үүднээс хэрэв уурхайлалт болон уурхайн бэлтгэл шатны барилга байгууламж, зам талбайн ажлыг хийж байх үед газрын гүнээс түүх соёлын дурсгалт зүйл гарсан тохиолдолд нэн даруй газар шорооны ажлыг зогсоон төрийн захиргааны төв байгууллагуудад нь мэдэгдэхээр төлөвлөн ажиллах болно.

2019 онд Археологийн судалгааг Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль Бизнесийн Удирдлага, Хүмүүнлэгийн Сургууль, Хүмүүнлэгийн салбар сургуулийн мэргэжлийн баг хийж гүйцэтгэсэн.

№	Нөлөөлөлд өртөх түүх соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээн ий цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1 2	АМТЗ-ийн талбай орчим болон дотор байх түүх соёлын өвүүд	Олборлолтын үйл ажиллагаанд түүх соёлын өвүүд илэрвэл	Шаардлагатай тохиолдолд дурсгалуудыг шилжүүлэ	-	-	-	2024 он	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
Нийт						1.0		

11. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Байгалийн болзошгүй гамшиг, аюулт үзэгдлээс үүдэн төслийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, дам нөлөөллөөр хүрээлэн буй орчныг бохирдуулах	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	Төслийн нийт ажилчдад	-		2024 он	ХАБЭА
2		Аянга, цахилгаанаас үүдэлтэй аюул ослоос сэргийлэхийн тулд аянга зайлуулагч байрлуулах	Засварын талбай ШТС	Үйл ажиллагааны төсөвт суулгах		Үйл ажиллагааны турш	
